



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 02 сарын 07-дөрөв

Дугаар 34

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас  
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.4, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Оюуны өмч, улсын бүртгэлийн өрөнхий газрын Төв аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 34,924,770.00 (гучин дөрвөн сая есөн зуун хорин дөрвөн мянга долоон зуун далан) төгрөгийн балансын үнэ, 22,647,112.57 (хорин хоёр сая зургаан зуун дөчин долоон мянга нэг зуун арван хоёр төгрөг тавин долоон мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий хавсралтад заасан барилга байгууламжийг Төв аймгийн Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2017 оны 19-07-020-477 тоот дүгнэлтээр ашиглах боломжгүй нь тогтоогдсон тул акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Оюуны өмч, улсын бүртгэлийн өрөнхий газрын дарга Р.Содхүүд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Үл хөдлөх хөрөнгийг акталж буулгах, газар (чөлөөлөгдөх талбай)-ыг албан ажлын зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайландаа тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮИН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Э.ЭРДЭНЭХИШИГ



D:\Huraldaanii\material\2018.02.07\togtool\03docx

00014

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн  
34. дугаар тогтоолын хавсралт

ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТӨВ АЙМАГДАХЬ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТӨЙ,  
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Ашиглал тад орсон он	Тоо хэм жээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Тайлбар
1	Конторын барилга (Төв аймаг, Зуун мод сум, 1-р баг)	1958	1	34,924,770.00	12,277,657.43	22,647,112.57	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ болон барилгад өргөтгөл хийснээс болж үлдэгдэл өртөгтэй, санхүүгийн тайлан тэнцэлд 2000 оноор ашиглалтад орсон хугацаатай байна.
	Нийт дүн			34,924,770.00 (гучин дөрвөн сая есөн зуун хорин дөрвөн мянга долоон зуун далан төгрөг)	12,277,657.43 (арван хоёр сая хоёр зуун далан долоон мянга зургаан зуун тавин долоон)	22,647,112.57 (хорин хоёр сая зургаан зуун дөчин долоон мянга нэг зуун арван хоёр төгрөг тавин долоон мөнгө)	